



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 01 өдөр

Дугаар A/104

Мөрөн сум

Захирамжийн холбогдох хэсгийг
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Захиргааны өрөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 47 дугаар зүйлийн 47.1.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дахь зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. “Газар эзэмших эрхийн гэрчилгээ шилжүүлэх тухай” аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/69 дүгээр захирамжийн хавсралтын 5 дахь хэсэгт заасан Мөрөн сумын 8 дугаар баг, Согоот-2, 217 тоотод байршилтай үйлчилгээтэй орон сууцны зориулалт бүхий 6712016568 нэгж талбарын дугаартай 3614м² газрыг эзэмшигч Дэндээвийн Чулуунбаатар (ЦВ69021630)-аас бусдад шилжүүлэхдээ зохих этгээдийн нэр дээр шилжүүлэгдээгүй байх тул уг захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

2. Дээрх захирамжаар газрын кадастрын мэдээллийн санд алдаатай бүртгэгдсэн мэдээллийг газрын кадастрын мэдээллийн сан, улсын бүртгэлийн мэдээллийн сангаас хасалт хийж, гэрээг цуцлах ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН